



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 4/19

Баян-Овоо

**Байгууллагын үндсэн хөрөнгөнд
орлого авах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолын хавсралт, 2022 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын 2.2.6, 5.1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 253 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2024 оны үр дүнд суурилсан санхүүжилтээр “Авъяаслаг Дадалчууд 2025” урлагийн наадам, “Мөнгөн өвөл 2025” сүлд модны наадамд урлаг уран бүтээл туурвихад зориулан худалдан авсан 9523,4 (Есөн сая таван зуун хорин гурван мянга дөрвөн зуун) төгрөгний үнэтэй 7 төрлийн 28 ширхэг бараа материалыг байгууллагын хөрөнгөнд орлого болгон бүртгэж авахыг нягтлан бодогч (Э. Өлзийсайхан)-д даалгасугай.

2. Байгууллагын хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж, холбогдох тайлан мэдээ танилцуулахыг байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн дарга (О. Насанжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ш. ГАНГАНТУУЛ